

**ТҮШИГ УУЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

[Санхүүгийн болон үйл ажиллагааны]

тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.5 дахь заалтууд болон **“ТҮШИГ УУЛ”** ХК-ийн 2017 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. **“ТҮШИГ УУЛ”** ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагаа зогсонги байдалтай хэвээр үргэлжилж, алдагдалтай ажилласантай холбогдон ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. 2017 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигтай ажиллах талаар идэвхи санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Батсайхан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/ Ж.БАЯРАА /

“ТҮШИГ УУЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Г

томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтууд болон “ТҮШИГ УУЛ” ХК-ийн 2016 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ж.Баяраа ✓
2. Ж.Батсайхан ✓
3. Б..Бямбадорж
4. Л.Ганчимэг ✓
5. Б.Үүрийнцолмон ✓
6. П.Пүрэвдавуу ✓

Хоёр. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Б.Гантулга
2. Б.Аюуш ✓
3. Н.Энхжаргал ✓

Гурав. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Ж.БАЯРАА/